

Концессын хураамжууд гэж юу вэ?

Концессын хураамжууд (эсвэл хүлээн авагчийн хураамж) нь телевиз болон радиогийн долгион хүлээн авсан, эсвэл тухайн дохиог дахин гаргах чадвартай хүлээн авагчтай иргэд бүрийн төлдөг төлбөр юм. Гар утаснаас хураамж авдаггүй бөгөөд утсан дээрээ MF радио, DVB-T тааруулагчтай байсан ч төлбөр авахгүй. Хураамжийг компьютероос ч авдаггүй (телевиз тааруулагч карттай бол хураамж авна).

Хэн концессын хураамжийг төлөх вэ?

Концессын хураамжийг телевиз болон радиогийн долгионтой өрөх бүр төлөх ёстой. Үндсэндээ та эрчим хүчний төлбөр төлөгч болмогц та телевиз, радиогийн долгион хүлээн авах боломжтой тул энэхүү төлбөрийг төлөх ёстойд тооцогддог (хүлээн авагч ашигладаг эсэх нь хамаагүй).

Хураамжийг өрөх бүр нэг төлөх бөгөөд та хэд хэдэн хүлээн авагчтай байж болно. Та хүлээн авагчийг 1 сараас дээш хугацаагаар зээлсэн ч гэсэн төлбөрөө төлөх ёстой (хэдийгээр та эзэмшигч биш боловч хүлээн авагчийг ашигладаг).

Хэрвээ та хувиараа бизнес эрхлэгч бол бизнестэй холбоотойгоор болон бусад ашигладаг хүлээн авагч бүрд нэмэлт төлбөр төлнө.

Би концессын хураамжийг төлөх ёстой гэдгээ яаж мэдэх вэ?

Төлбөрийг төлөхийн тулд хүн бүр хүлээн авагчийг худалдаж авснаас хойш эсвэл жишээ нь, нүүсэн тохиолдолд 15 хоногийн дотор бүртгүүлэх үүрэгтэй. Та шуудангийн аль ч салбар эсвэл цахимаар бүртгүүлж болно. Хэрэв та цахимаар бүртгүүлэх сонголтыг хүсвэл Чехийн телевиз, Чех радиогийн цахим хуудсаар бүртгүүлэх шаардлагатай бөгөөд та өөрийн тухай мэдээлэл болон төлбөрийн дэлгэрэнгүй мэдээллийг бөглөнө. Хэрэв та бизнес эрхэлдэг бол хэдэн телевиз болон радиотойгоо тайлагнах хэрэгтэй.

Телевиз, радиогийн хураамжийг төлөөгүй айл өрхүүдэд 2017 оноос хойш албан бичгээр мэдэгддэг болсон. Тиймээс та мэдээллийн захидлаар хүлээн авах боломжтой. Хэрэв та хүлээн авагч эзэмшдэггүй бол захидал хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор телевиз, радио хүлээн авагч байхгүй гэдгээ албан ёсоор мэдэгдэх боломжтой.

Концессын хураамжийг хэн төлдөггүй вэ?

- БНЧУ-д удаан хугацаагаар оршин суух зөвшөөрөл (ажилын картыг оруулаад) эсвэл байнгын оршин суух зөвшөөрөл аваагүй гадаадын иргэд. Энэ нь урт болон байнгын оршин суух эрхтэй гадаадын иргэд хураамж төлдөг, харин орогнол, нэмэлт хамгаалалттай, урт болон богино хугацааны визтэй гадаадын иргэд хураамж төлдөггүй гэсэн үг юм.

- өрхийн бүх гишүүд дүлий эсвэл хараагүй төлөхгүй
- өнгөрсөн улиралд амьжиргааны доод төвшнөөс 2,15 дахин бага орлоготой иргэд төлөхгүй (2022 оны амьжиргааны доод хэмжээ нь 4250 крон)
- өнгөрсөн улиралд өрхийн бүх гишүүдийн цэвэр орлогын нийлбэр нь амьжиргааны доод төвшнөөс 2,15 дахин бага орлоготой бол төлөхгүй

Концессын хураамжийн төлбөр хэд вэ?

Телевизийн төлбөр нь 135 крон бол радиогийн төлбөр нь 45 крон юм.

Концессын хураамжийн хэдэн удаа төлдөг вэ?

Төлбөрийг сард нэг удаа, сарын 15-ны дотор төлнө. Бизнес эрхлэгчид улиралд тутам төлнө (Чех телевиз болон Чех радиогийн дансанд шууд хийнэ).

!!! АНХААР !!!

Концессын хураамж төлөөгүй тохиолдолд торгууль ноогдуулж болох уу.

- Чехийн телевизийн зүгээс 10,000 крон, харин Чехийн радиогоос 5,000 кроноор торгоно.
- *Бид оршин суух сэдвээр дараах зүйлсийг бэлтгэж байна: ачаа – захидал хүргэх.*